

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-04-28

Өндөртөлгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 05 дугаар сарын 05-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Засгийн газрын 2026 оны “Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай” 127 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
2.	Засгийн газрын 2026 оны “Хүнсний ногооны үнийн өсөлтөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 122 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
3.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар албан даалгаврын дагуу төсвийн зарлагын санхүүжилтийг төсвийн орлогын бүрдүүлэлт, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлагатай уялдуулан эрэмбэлж санхүүжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах.	Санхүү төрийн сангийн хэлтэс, Нийт байгууллагууд
4.	Дүүргүүд нийслэлд төвлөрүүлэх төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлэх.	Засаг даргын орлогч, Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
5.	2026-2027 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
6.	Нийслэлд хийгдэх зам, инженерийн байгууламжийн бүтээн байгуулалт, засварын ажилтай холбоотойгоор авто замын хөдөлгөөн болон хэрэглэгчдийн цахилгаан, ус түгээлтийг нээх, хаах хугацааг иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж ажиллах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, инженер хангамжийн байгууллагууд
7.	Хот нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд дүүргийн удирдлагууд өөрсдийн нутаг дэвсгэртээ ажиллах, дүүргийн газар нутгийн хэмжээ, нийтийн эзэмшлийн зам талбайн хэмжээ, суурьшлийн бүс зэргийг харгалзан дүүргийн төвлөрүүлэх орлогоос тодорхой лимит олгодог болох.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс
8.	Худалдан авах ажиллагааны хүрээнд цахим худалдан авалт, харьцуулалтын аргаар хийхээс бусад эрх шилжүүлсэн шийдвэрүүдийг хүчингүй	Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба

	болгох.	
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
9.	Нийслэлийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
10.	Газрын зөрчил арилгах талаар авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавих, зөрчлийг арилгуулах	Засаг даргын орлогч, Газар зохион байгуулалтын алба
11.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын ажлыг эрчимжүүлэх, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
12.	Багахангай марафон-2026 УАШТ-нийг зохион байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Ажлын хэсэг
13.	Үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн, Food Festival арга хэмжээг зохион байгуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Ажлын хэсэг
14.	Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргатай уулзах уулзалт зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
15.	СӨБ, ЕБС-ын төгсөлт, элсэлттэй холбоотой гарч буй төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд
16.	Аж ахуйн нэгж байгууллагуудын нэгдсэн тооллого зохион байгуулах	Статистикч, Хороод
17.	Аудитын дүгнэлт зөвлөмжийг дүгнэх, анхаарах асуудлыг хэлэлцэх танилцуулга, уулзалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дотоод аудитын алба
18.	Тодотголоор орсон хөрөнгө оруулалтын ажлыг зарлах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ